

ҮЗСЭН ДАЛАЙ

БНХАУ-ын төрийн шагналт, Өвөр Монголын алдарт дуучин М. Лхасүрэн 1985 онд тус улсад Өвөр Монголын урлагийн хэсгийн хамт ирж Улаанбаатар, Дархан хотуудад тоглолт хийсэн үеийн сэтгэгдлээ Хятад болон Өвөр Монголын сонин сэтгүүлд, өргөн нийтлүүлжээ.

Өвөр Монголын «Хун галуу» хэмээх онол, утга зохиолын сар тутмын сэтгүүлийн 1986 оны № 4-т М. Лхасүрэнгийн бичиж нийтлүүлсэн «БНМАУ-д айлчилсан тэмдэглэлийг» уншигчдад толилуулж байна.

Үзсэн нь далай
Үзээгүй нь балай
(Ардын цэцэн үг)

1985 оны хуанлийн сүүлчийн хэдхэн хуудсыг эргүүлж байсан үед, эх улс, ард түмнийхээ найдлагаар, энгүй зузаан нөхөрлөл өвөрлөж, Монгол улсын Улаанбаатар, Дархан хотуудаар айлчлан аялгуут дуугаа өргөж, ах дүүгээ эргэж явлаа.

Хойч залгамж хэмээгдэх уран бүтээлчдийн эгнээнд багтан, манай түүхэнд тэмдэглүүштэй энэ удаагийн айлчлалд оролцсондоо би их баяртай байлаа. Хэдийгээр айлчилж зочилсон хугацаа богино боловч, үзэж сонссон зүйл олон, манайхны найз нөхөд, айл саахалтынхан ч сонин сайхныг сонсох гэж их цувардаг болов. Энэ нь ч манай хоёр улсын ард түмэн сайн сайхан харилцахыг шаардаж байгаа хүсэл яахын аргагүй мөн байнам. Тэгэхдээ бид эх улсынхаа ард түмний нөхөрлөлийг өвөрлөн очсон, мөн ч монголын ард түмний нөхөрлөлийг өвөрлөн ирсэн. Энэ сайхан сэтгэл тэнүүн, шижир алтан цаг үед амгалан хорвоод адилхан бүүвэйлэгдсэн ах дүү хөрштэйгөө уулзан золгох олдошгүй аз завшаан хүртсэний жаргал заяандаа «Үзсэн далай» хэмээх сэдвээр хомсхон ойлголтоо танилцуулахыг хичээв.

ХАЛУУН ДОТНО УГТАЛТ

«Тоглолтыг хэр зэрэг хүлээн авав» гэдгийг та бүхэн сониноос үзсэн байх. Гэхдээ чухам хэр зэрэг болов гэдэгт анхаарал тавьж байгаа та нарт миний хэлэх зүйл бол, ноднин намар Монгол улсын ардын дуу бүжгийн чуулгыг манай оронд хэрхэн угтсан, монголын үзэгчид ч биднийг тийн хүлээн авсан. Иймээс тоглолт тун амжилттай болсон юм гэдгийг би эрхэм хүндэт уншигч нартаа мэдэгдэж байна. 12-р сарын 21-ний орой Д. Нацагдоржийн нэрэмжит Улсын драмын академик театрт бид анхныхаа тоглолтыг хийсэн юм. Торгон хөшиг сөхөгдөж концерт эхлэхэд тусгай урилгаар манай тоглолтыг зарласан монгол улсын ардын дуу бүжгийн чуулгын авьяаслаг уран уншигч, залуу жүжигчин Аюуш бүсгүй торгон тэрлэг өмсөж, Өвөр Монголын залуу жүжигчин Гэгээншанд бүсгүй ордос нутгийн хувцаслалтаар хувцаслаж гар гараасаа барилцан тайзнаа гарч төрөлх хэл төв халх аялгуу, сурсан хэл хятадаар хослон тоглолтыг зарламагц, алга ташилтын дуу нижигнэн, ах дүүсэг агаар амьсгалаар бялхаж байлаа. Дараа нь манай тоглолт бүхэлдээ монгол хэлээр явагдсан. Энэ нь үзэгчдэд улам илүү таалагдаж, хэл улаа мэдэлцэхээс гадна сэтгэл санаагаа ойлголцох үнэнч нөхөрлөлийн өндөрт хүрсэний зангилгаа гэж үзэж болно. Алд торгон хадгаа алган дээрээ дэлгэж, алтан цөгц аяган-

даа айраг сүүгээ мэлтэлзүүлж аман ерөөлөө айлтган, аялгуут дуугаа эхлэнгүүт алдарт монголын соёлтой боловсон үзэгчид танхим дүрэн шагшиж, тагнай ташин сонирхосныг хэлэх юун билээ. Найрамдал ийм л болоход ард түмэн сэтгэл тэнүүн болдог байна.

Манай жүжигчдийн дотроос алдарт дуучин Мулан, авьяаслаг дуучин Алтай, Насан нар өөр өөрийнхөө онцлогоор ард түмнийхээ өмнөөс ах дүү хөршийн анд нөхөддөө ая барин дуулж, амар эрэн ёслоход жүжигчид, үзэгчид бүгдээрээ сэтгэл дүүрэн цэнгэн жаргаж байсан гэдэг ч үнэн. «Сайхан бүжиг», «Баясал» бүжиг, «Ордос ардын дуулалт бүжиг» алдарт бүжигчин Одмол, Бадам, ахмад жүжигчин Журамт нарын тоглолтоор драмын театрын сүрлэг тайзнаа ээрүүл шиг эргэлдэж, эрвээхэй шиг дэрвэлзэж ч байсан. Монгол морины туурай тачигнаж, морин хуурын эгшиг хангинаж, уртын дууны цоор түрж, уяхан лимбийн айзам жингэнэхэд алга ташилтын дуу өндөрсөж байсан. Амжилт олсны гэрч энэ байх аа. Улаанбаатарын радио хороо нэвтрүүлэгтээ алдарт хөгжмийн зохиолч Тулгуурыг «Авьяаслаг сайн зохиолч» гэж үнэлсэн. Үнэндээ нөхөр Тулгуурын уран бүтээл манай тоглолтод чухал байр эзэлж байснаар барахгүй өөрөө ёочир (хуучир байх) хөгжмөөр хөгжимдөж үзэгчдийн анхаарлыг татсан. Нэн ялангуяа морин хуурыг бол тусгай мэргэжилтэн ба үзэгчид тун дээгүүр үнэлсэн билээ. Ардын жүжигчин ба алдарт морин хуурч Жамъян гуай биеэрээ буудалд ирж манай хоёр залуу шавийн хөгжимдөх мэргэжилд өндөр үнэлэлт өгсөн. Жамъян гуай бол 50-иад оны үед манай орны алдарт морин хуурч Сандүүрэн (нас барсан)-тай тун их найртай байсан бөгөөд багш шавийн барилдлагаатай улс байжээ. Ойрын жилүүдэд манай орны алдарт морин хуурч Ч. Булагийг улсдаа урьсан хүн. Энэ удаа алдарт морин хуурч Билэгбаатартай танилцандаа өвгөн гуай сэтгэл хангалуун байлаа. Буудлын хүлээн авалтын өрөөнд монгол ба хятад улсын нутаг нутгийн даралт, хуурдалтаар, ардын дууг өөр, өөрсдийн онцлогоороо татаж дарж, нөхөрсөг байдалтай байсныг тэмдэглэмээр бодогдсонд гэрэл зураг, дуу бичлэгийн материал үлэмжхэнийг үлдээж авсан юм. Энэ нь манай дуу үндэсний дуу хөгжим урлагт их түлхэц болох нь дамжиггүй. Үзэгчид «Дарамбазар гуай! Та ч морин хуураар дуулдаг дуучин байх шив, Үнэхээр сайхан хөгжимддөг хүн байна» гэж баяр хүргэж байсныг санахад морин хуур бол хөгжим шүү дээ, гэхдээ «хуурандаа дуулдаг» гэдэг нь сэтгэлийн хөвчийг хөндсөн, гоо сайхны хүртээл болсон гэсэн өндөр үнэлэлт мөн аж. Ч. Булагийн зохион найруулсан «Түмэн агтны төвөргөөн»-ийг хөгжимдөөд, «Түмэн агтын эзэн» хэмээх цол хүртэв. Үдэн мордуулахдаа тэд «Түмэн агтын эзэн минь эргээд ирэхдээ буман агтын эзэн болоод ирээрэй!» гэж ерөөсөн байлаа. Монголын ард түмний энэ сайхан ерөөл бат орших болтугай! Манай улсын шагнал хүртсэн ерөөлч Манжмятавын Доржринчин «Дархан хотын магтаал» гэдэг ерөөлөөр Дарханы залуучуудын театрын жүжигчид тэд бүрнээр нь бичүүлж авсан билээ. Манай оронд ирсэн дэлхийн нэртэй жүжигчдийн нэрст Доржринчин нэмэгдсэн, энэ бол сайн хэрэг гэж би бодож байна гэж төрийн шагналт яруу найрагч Д. Пүрэвдорж надтай уулзахдаа хэлж билээ. Ерөөлч Доржринчингийн энэ амжилтад бид баярлаж байна.

«Арван тавны сар нь агаар дээрээ дэгдлээ...» гээд дуулахтай зэрэг цохилго, хуваарийг нь тааруулж алга ташиж халуун баяр хүргэж байгаад нэгэн ахмад жүжигчин хэлсэн нь: «Тавиад оны үед бид энэ дууг хамт дуулж байсан. Та нар энэ дуугаа дуулахтай зэрэг бид тавиад оны нө-

хөрлөл найрамдлыг саналаа» гэж их сэтгэл догдлон баяр хүргэсэн. Энэ бол зөвхөн хувь хүний хүсэл сонирхлыг харуулж байгаа явдал бус. Хорин хэдэн жил өнгөрөөд дахин сайжирч өөдлөж байгаа ард түмний харьцаа найрамдлыг тусгаж байх учиртай гэж би ойлгоно. «Нохойн хэрүүл хүнд хамаагүй, ноёдын хонзон бидэнд хамаагүй, хятад, монголын ард түмэн гар барилцан ёсолж, дэлхий дахины найрамдлын хөгжилд дэмжлэг тусыг хөгжөөж байна» гэж тавин оны есөн сард Ц. Дамдинсүрэн тэмдэглэсэн байдаг. Хорь гаруй жилийн хугацаанд манай хоёр улсын хил хязгаар амгалан тогтуун байдалтай, оршиж, сүүлийн жилүүдэд харилцаа холбоо алгуур сайжирч, сэргэж байгаагийн бодит илрэлд манай урлагийн бүлгэм Монголд айлчилсан, монголын урлагийн хэсэг манай улсад ирсэн явдал гэрч болох юм. Иймээс Монголын ард түмэнтэй үеийн үед нөхөрлөн явна гэдэгт бид итгэж байна.

Театрт үзсэн сонин

Юуны хүн юундаа гэгчээр монгол улсад айлчилж байх хугацаандаа утга урлагийн хүмүүстэй өргөнөөр ярилцаж нэлээд юм ойлгосон билээ. Театраа эзэмшиж байгаа нь их эмх дэглэмтэй бөгөөд соёлч боловсон санагдлаа. Улаанбаатар хотод тоглосон театр бол дээр дурдсан драмын театр, нөгөө нь Монголын үйлдвэрчний эвлэлийн соёлын ордон болно. Драмын театр бол драмын чуулга болон Ардын дуу бүжгийн чуулга хамтран эзэмшиж ээлжээр тоглодог тусгай театр юм. Тус театрын бүх тайзны тоноглол, төхөөрөмжийг зохицуулан угсраад тогтмол байранд байлгаж үргэлж тоглолт хийдэг бөгөөд энгийн үедээ тэд театртаа ажиллаж боловсордог тул албан контортоо, ажиллах тасаг нь мөн театрын ар тайзнаа хоёр давхарт байдаг нь их таатай нөхцөлийг бүрдүүлж байна. Тус театр 600 үзэгчдийн суудалтай. Ажиглаваас анхны жилүүдийн барилга бололтой. Гэвч эзэмшиж эдэлсэн нь сайн тул хүнд шинэ барилга шиг санагддаг. Энэ театрт тоглолт болоход тайзны арын дуучид, бүжигчид, хөгжимчид, хувцаслах, засал чимэглэл хийх, сургууль дасгал хийх, нүүр будах зэрэг өрөөнүүдийг тусгайлан бэлтгэснээр барахгүй, тайзны ажилтан, гэрэл зохицуулагч, хувцас хариуцагч, нүүр будагч, микрофон хариуцагч нар тус тусдаа ажлынхаа байр эзлэн манай тоглолт амжилт олох нөхцөлийг бүрэлдүүлж байлаа. Тэдний зан авир туйлын дотносог, ажлын хариуцлага чанга нямбай байснаас гадна нэртэй жүжигчин нар ус ундаа, чихэр жимс зөөж, үйлчилж гүйлдэнэ. Энэ бүхнийг харсан хүнд ямар нэгэн харь өөр сэтгэгдэл төрөх биш харин цайлган цагаан, үнэнч ёсорхог монгол занд нь согтуурнам билээ. Олны танил, манай улсад айлчилсан улсын гавьяат жүжигчин Д. Самбуу биднийг угтан зочлох ажилд эхнээс аваад дуустал оролцсон. Тэдэнд ямар нэгэн ажил тушаал алдар цолын ялгаа байхгүй бүхий л чадал хүч, хөдөлмөр оюун ухаанаа социалист нийгэмдээ өгдөг эрхэм нандин зан чанартай байдаг нь илэрхий байлаа. Тайзны ар тал нь жүжигчин хүний ажиллах амьдрах суурин байхад цэвэр ариун гэдгийг нь өгүүлэх юун аж. Модон шалыг гэрэл цацартал зүлгэж, аливаа тоног төхөөрөмж, хөшигний оосоо, хөгжмийн хайрцаг нь хүртэл тоосгүй цэвэр харагдсан бөгөөд газар сайгүй нулимаж, гарын аяар эвдэлдэг зарим болих суртал, боловсон бус үзэгдэл тэр газар оронд зай байдаггүй нь илхэн бөгөөд «тамхи татвал жорлонд оч» гэсэн бичиг байх нь харагдлаа. Ийм боловсон байдлыг бид суралцах нь чухал бус уу? Соёл гэдэг зөвхөн хэдэн үсэг танихын төдий бус, түүхийн, нийгмийн үндэс угсааны бүх талыг хамарсан нарийн зүйлийг хэлж байгаа учраас бид

соёлтой боловсон монгол зангаа бүү хаяъя аа! Тайзны арын өрөө тасалгаа, амрах хувцаслах, байшингийн модон шалан дээр гоё хээтэй хивс дэвссэн болохоор надад театр гэж санагдахгүй ямар нэгэн дээд зэргийн буудалд орсон шиг бодогдож билээ. Эдгээр өрөө тасалгааны ханан дээр театрын нэр алдартай бүх жүжигчдийн гэрэл зургийг тайлбар тодотголтой хийж өлгөсөн нь монголын ард түмэн энэ олон нэр алдартай хүмүүсээ хайрлан хүндэтгэдгийн илрэл бөгөөд тэд ийм олон алдарт хүмүүс тэйдээ бахархан байдаг ажгуу. Тиймээс хүмүүсийн урагшлан давших, тэмүүлэн суралцахад үлгэр дууриал болдог байна. Дуучдын сургуулилах өрөөнд гурвалжин том төгөлдөр хуур угсраатай, хана тойруулан сандал тавьж, сандал бүхний өмнө дууны ном тавьсан бөгөөд голд нь нэг ус шүршдэг нарийн төхөөрөмж байгааг сонирхон лавлавал дуучдын хоолой хатахаас сэргийлэн чийглэг байлгах ажиллагаатай эд гэнэ ээ! Үнэхээр сонин сонин юм сэддэг улс даа.

Улаанбаатарт бид дөрвөн удаа тоглох байсан учир олонхи үзэгчид билет олж чадсангүй гэцгээж байлаа. Гэлээ ч хойд үүдээр оръё! өмнө хаалганд нь шахалдъя! гэж байгаа нь ер харагдсангүй. Үзэгчдийн боловсоныг нэн ч гайхмаар. 12-р сарын 20-ны орой Улсын дуу бүжгийн чуулгын гоё сайхан тоглолтыг монголын үзэгчидтэй драмын театрт бид хамт сонирхсон. Тэгэхдээ тэд биднийг Хятад улсын монгол хүн ямаршуу байдаг юм бол гэж эвэртэй туулай үзсэн юм шиг үймэлдсэнгүй. Театрын өмнө танхимд үүд алхагсдыг, нүүрлэн Д. Нацагдоржийн хөшөөтэй, танхимын хоёр талыг ажвал яг бүрэн бараатай дэлгүүрийн хувцасны лангуу мэт гоё сайхан тавцангийн дотор үзэгчид, үнэг, булга тэргүүтэн ангийн үсээр хийсэн монгол, орос маягийн малгай, дээл зэрэг гадуур хувцсаа үйлчлэгчид өгч өлгүүлнэ. Тэд гартаа барьсан цүнх, үнэ өртөгтэй зүйлээ үйлчлэгч бүсгүйд тушаан том толины өмнө очиж гэзэг үсээ самнаж янзлаад театрт орж нам жим сууцгаана. Тоглолт бүрд баяр хүргэж алга ташина. Ханиаж нулимах, шивнэлдэж шуугих, самар цөмөх, хүүхэд шуухад шахалдах явдал энд алга! Тоглолт дуусахаас өмнө, талаас илүү нь явчихдаг үзэгдэл нэг ч байдаггүйг нь би магадласан. Жүжигчин хүний хөдөлмөрт ийм ёсорхог үзэгчид таарвал юутай сайхан заяа вэ? Эдгээр байдал нь биднийг хөдөө тоглоход, малчид бороо орж байсан ч хөдөлдөггүйг санагдуулна.

Бүтэн сайн өдөр бид Үйлдвэрчний эвлэлийн ордонд тоглолт хийв. 1981 онд Үйлдвэрчний Төв Зөвлөлөөс хоёр танхим шинээр цогцлон байгуулж, шинэчилсэн тоноглолтой мянган суудал бүхий концертын танхим, хоёр мянга гаруй суудалтай кино заал байгуулжээ. Энэ ордондоо 26 дугуйлан, 60 анги, 1000 гаруй залуучуудыг зохион байгуулж долоо хоногт 2 удаа хичээллэдэг. Үүнд бүжиг, хөгжим, зураг, шатар, спортын төрлүүд багтдаг. Ийм их сайхан сүрлэг ордны төхөөрөмж, үйлчилгээ, орчин нөхцөл, жич эзэмших эдлэх ёс журам нь драмын театраас давуу юу гэхээс биш дутуугүй юм. Энэ ордонд манай тоглолтыг сонирхсон үзэгчид бол үйлдвэрчин ард дийлэнх нь байлаа. Тоглолтын дараа бидний автобусыг тойрон баахан үзэгчид гарын үсэг зуруулж дурсгал үлдээнэ гээд хүлээж байсан. Идэр есийн хүйтэнд ингэж хүлээж зогсоно гэдэг ёстой «хайртай хонгор чамайгаа хүлээсээр удлаа, харин чи минь хүрээд ирэхгүй нь юу вэ?» гэгч болж байх шиг надад санагдаж баярын нулимс асгаруулан жаргалын далайд умбаж байлаа.

Миний ойлгож байгаагаар Сүхбаатарын талбайн зүүн талд сүндэрлэж байгаа Улсын дуурь бүжгийн академик театр бол хуучин төв театр байж, манай Өвөр Монголын дуу бүжгийн чуулга 1959 онд Монголд айлчлах-

даа энд тоглолт хийсэн юм байжээ. Энэ театрт дөрвөн зуу гаруй хүнтэй, гучаад гоцлол дуучинтай, тэд Зөвлөлт, Болгар мөн өөрийн оронд дээд боловсрол олсон жүжигчид мөртөө дэлхийн сонгодог зохиолуудыг тоглодог бөгөөд голчлон Мөрдорж, Гончигсумлаа, Лувсаншарав нарын дуурийн зохиолыг тоглодог ба эрхэм уншигчдын мэдэж байгаа «Учиртай гурван толгой»-г одоо даруй хоёр мянга жаран найм дахь удаагаа тоглож байна. Сонин болгон ярих зүйлээ үүгээр түр сүүл хураалаа. Та бүхэнд талархаж байна.

1985 оны 12-р сар. Улаанбаатар хотноо

Монгол бичгээс буулгасан М. ЗЭНЭЭ